



# АМЧАМ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

---

**ЭРЧИМ ХҮЧ**

2025 оны 9-р сар

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам)-ын Эрчим хүчний хороотой хамтран энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулав. Бодлогын баримт бичгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглах, хэвлэн нийтлэхэд АмЧам-аас зөвшөөрөл авна.

# Удиртгал

Уул уурхайн тэлэлт, хүн амын өсөлттэй холбоотойгоор эрчим хүчний эрэлт нэмэгдэж байгаа боловч эрчим хүчний систем өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангахад сорилт бэрхшээлтэй тулгарсаар байна.

Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт төрийн санхүүжилт болон хөгжлийн олон талт түншүүдээс олгосон хөнгөлөлттэй зээл, техникийн туслалцаа, төслийн санхүүжилт зэрэгт тулгуурлаж ирсэн бол цаашид энэ салбарыг зах зээлийн зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Энэ нь Монгол Улс эрчим хүчний бие даасан байдалд хүрэх, дотоодын үйлдвэрлэлээрээ эрэлтийнхээ дийлэнх хэсгийг хангадаг болоход чухал юм.

Үүний тулд, хувийн хэвшил эрчим хүчний уламжлалт эх үүсвэрт төдийгүй цэвэр болон сэргээгдэх эрчим хүч, устөрөгчийн технологи зэрэг эрчим хүчний шинэ тутам хөгжиж буй эх үүсвэрийг эрэлхийлэх боломжтой. Төрөөс бодлогын дэмжлэг үзүүлж, хууль эрх зүй, үнэ тариф, системийн реформыг үр дүнтэй хийсэн цагт хувийн хэвшил энэ салбарт тогтвортой, урт хугацааны хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдэх юм.

Энэхүү бодлогын баримт бичигт Монгол Улсын эрчим хүчний тогтолцооны өнөөгийн байдал, хууль эрх зүй, бодлогын орчны талаар дэлгэрэнгүй дурдаж, тулгамдаж буй сорилт, бэрхшээлийг өгүүлэхийн зэрэгцээ төрөөс эрчим хүчний салбарт эхлүүлсэн реформын хүрээнд хийгдсэн өөрчлөлт, шинэчлэлийн талаар оруулсан. Түүнчлэн, АмЧам-ын Эрчим хүчний ажлын хэсгийн гишүүдийн оролцоотойгоор эрчим хүчний салбарт хувийн хэвшлийг оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн, тулгамдаж буй сорилт бэрхшээлийг системтэйгээр шийдвэрлэхэд туслах зөвлөмжийг бодлогын баримт бичигт тусгасан болно.



# МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТОГТОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын эрчим хүчний систем нь ойролцоогоор 3.5 сая хүн амын хэрэгцээг хангаж ажилладаг билээ. 2024 оны байдлаар хүн амын 98 хувь нь цахилгаан эрчим хүчинд холбогдсон байгаа нь сүүлийн 20 жилийн хугацаанд эрчим хүчний хүрэлцээ, хангамжид ихээхэн дэвшил гарсныг харуулж байна ([Эрчим хүчний яам](#)). Гэсэн хэдий ч эрчим хүчинд холбогдсон байдал нь хангалттай бус, эрчим хүчний аюулгүй байдал, үр ашигтай үйл ажиллагааны шаардлага хангахгүй байна.

Дотоодын үйлдвэрлэл, цэвэр импортыг багтаасан эрчим хүчний хангамж нь нүүрсхүчлийн хийг ихээр ялгаруулдаг хэвээр байна. Олон улсын эрчим хүчний агентлагийн ([ОУЭХА](#), 2022) мэдээлснээр, нүүрс нь нийт эрчим хүчний хангамжийн 70 орчим хувийг эзэлдэг бол импортолж авсан газрын тос (27.6%), био түлш, хаягдал (1.6%), сэргээгдэх эрчим хүч (1%) бүрдүүлж байна. Дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлд нүүрс (97.8%) зонхилж байгаа бол түүхий газрын тос (1.5%) багахан хэсгийг эзэлдэг.

Цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэхэд, Монгол Улс нүүрснээс ихээхэн хамааралтай хэвээр байгаа бөгөөд нийт үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний 74.6 хувийг нүүрснээс гарган авч байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос мэдээлснээр, сэргээгдэх эрчим хүч нь нийт суурилагдсан хүчин чадлын 18.3 хувийг эзэлдэг боловч цахилгаан эрчим хүчний хангамжийн ердийн 9.6 хувийг үйлдвэрлэдэг ([ЭХЗХ](#), 2024).


Эрчим хүчний эцсийн хэрэглээ буюу эцсийн хэрэглэгчдийн бүх салбарт ашигладаг эрчим хүчний тухайд авч үзвэл энэ харьцаа өөр байна. ОУЭА-ийн мэдээлснээс үзвэл, газрын тосны бүтээгдэхүүн хамгийн их хувийг (35.9%) эзэлдэг бөгөөд гол төлөв тээвэр, уул уурхайн салбар хэрэглээний ихэнх хэсгийг бүрдүүлж байна. Дулаан (29.6%), нүүрс (17.9%), цахилгаан эрчим хүч (15.3%) нь эрчим хүчний эцсийн хэрэглээнд чухал үүрэгтэй байгаагаас үзэхэд, дулаан, тээвэр, аж үйлдвэрийн үйл ажиллагаа зэрэг эрчим хүчний эцсийн хэрэглээний хэрэглээнд чулуужсан түлш давамгайлсан хэвээр байгааг харуулж байна.

Салбараар нь авч үзвэл, ОУЭА-ийн статистикийн мэдээллээр, аж үйлдвэрийн салбар нь эрчим хүчний хамгийн их хэрэглэгч хэвээр байгаа бөгөөд нийт хэрэглээний 31.6%-ийг эзэлж байна. Тээврийн салбар нийт хэрэглээний 22.4%, айл өрхийн хэрэглээ 21.9%, бусад хэрэглээ (хувийн болон төрийн үйлчилгээ) 10.9%-ийг тус тус бүрдүүлж байна. Эдгээр тоо баримтаас үзэхэд, айл өрхийн дулааны хэрэгцээ болон эрчим хүч ихээр шаарддаг аж үйлдвэр, ялангуяа уул уурхай, барилга салбар нь эрчим хүчний тогтолцоонд давхар дарамт үзүүлж байна.



## ХУУЧИРСАН ДЭД БҮТЭЦ

Монгол Улсын цахилгаан эрчим хүчний систем нь Төвийн бүсийн эрчим хүчний систем (ТБЭХС), Баруун бүсийн эрчим хүчний систем, Зүүн бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн бүсийн эрчим хүчний систем, Өмнөд бүсийн эрчим хүчний систем гэсэн таван хэсгээс бүрдэж байна (Зураг 1). Эрчим хүчний цахилгаан хангамжийн хамгийн чухал систем болох ТБЭХС нь Улаанбаатар хотын хэрэгцээг хангаж, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний 90 орчим хувийг бүрдүүлдэг (АХБ, 2024). Цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн ихэнх хэсэг, ялангуяа ТБЭХС нь ЗХУ-ын үеийн технологид суурилсан. Голлох цахилгаан станцууд, ялангуяа Улаанбаатар хотод байгаа ДЦС-3, ДЦС-4-т нь засвар үйлчилгээтэй холбоотойгоор үүссэн ужгирсан асуудлууд, үр ашиг багатай байдал, байнгын осол гэмтэл зэрэг асуудал байсаар байна. Цахилгаан дамжуулах, түгээх үндэсний сүлжээний алдагдал 13%-иас давсан байгаа нь цахилгаан эрчим хүчний сүлжээ хуучирсан, автоматжуулалт маш бага хэмжээнд хийгдсэн зэргийн үр дагавар юм. ТБЭХС-нээс гадна, бүсийн эрчим хүчний сүлжээнүүдэд үр ашгийн асуудал ихээхэн тулгамддаг төдийгүй эрчим хүчний чанарын асуудал ч бий. Цахилгааны эрчим хүчний нэгдсэн сүлжээ байхгүй байгаа нь бүс нутгуудын хэмжээнд эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэхэд хүндрэл учруулж байна.



Зураг 1. Эрчим хүчний бүсийн сүлжээ

## ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ЭРЭЛТ


Хуучирсан дэд бүтэц болон сүлжээний алдагдлын зэрэгцээ, Монгол орны хатуу ширүүн өвлийн уур амьсгал нь халаалт, дулааны ихээхэн хэмжээний эрэлтийг бий болгодог бөгөөд халаалтын улирал нь есдүгээр сараас тавдугаар сар хүртэл ихээхэн удаан хугацааг хамардаг. Хурдтай хүрээгээ тэлж буй хотжилт болон эрчим хүчний хэрэглээ ихтэй аж үйлдвэр, түүний дотор уул уурхайн салбарын өсөлттэй холбоотойгоор эрэлт улам бүр нэмэгдэж байна. Оюутолгой, Тавантолгойн уурхай зэрэг томоохон төслөөс үүдэн, цахилгаан эрчим хүчний хэрэгцээ нь дотоодын үйлдвэрлэлээр хангах нийлүүлэлтээс давсан.

## НҮҮРСЭЭР БАЯЛАГ БОЛОВЧ ЦАХИЛГААН ХҮЧ ИМПОРТОЛДОГ

Монгол Улс нүүрсээр баялаг боловч цахилгаан эрчим хүчний цэвэр импортлогч хэвээр байна. 2024 оны байдлаар, дотоодод үйлдвэрлэдэг эрчим хүч нийт эрэлтийн 75.4%-ийг хангаж байв. Үлдсэн 24.6 %-ийг гол төлөв Хойд бүсийн эрчим хүчний системээр дамжуулан ОХУ-аас болон Өмнөд бүсийн эрчим хүчний системээр дамжуулан БНХАУ-аас хангаж байна (ЭХЗХ, 2024).

Хэдийгээр Монгол Улс өндөр агууламжтай коксжих нүүрс экспортолдог боловч дотоодын цахилгаан эрчим хүч нь бага агууламжтай эрчим хүчний нүүрсэнд тулгуурладаг. Шинээр цахилгаан станц барихад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд санхүүгийн болон хүнд суртлын саад тотгорын улмаас энэ нь удаашралтай байна. Дотоодын үйлдвэрлэлийн хангалтгүй байдал, өсөн нэмэгдэж буй эрэлт, одоо байгаа цахилгаан станцуудын хоорондын бүс нутгийн тэнцвэрт бус байдлаас үүдэн цахилгаан эрчим хүчийг импортлох шаардлагатай байна. Гадаад нийлүүлэлтээс хамааралтай энэ байдал ялангуяа хоёр их гүрний дунд байрлах Монгол Улсын геополитикийн байрлал болон сүүлийн үед ОХУ-ын цахилгаан сүлжээнд үүссэн тогтворгүй байдал зэргээс хамааралтайгаар, ноцтой эмзэг байдлыг үүсгэж байна.

# ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ОРЧИН



Монгол Улсын эрчим хүчний хууль эрх зүйн үндэс нь цахилгаан болон дулааны эрчим үйлдвэрлэл, дамжуулалт, түгээх, нийлүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулдаг 2001 онд батлагдсан Эрчим хүчний хуульд суурилдаг билээ. Эрчим хүчний салбарын өөр чухал хууль эрх зүйн баримт бичиг болох Сэргээгдэх эрчим хүчний хуульд (2007 онд батлагдаж, 2015 болон 2019 онд тус тус нэмэлт өөрчлөлт орсон) өртөг багатай, хувийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор тогтмол тарифаас өрсөлдөөнт тарифт шилжүүлэх нэмэлт өөрчлөлтийг

хийсэн байдаг. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль нь заавал хийгдэх аудитын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн стандарт, урамшуулалын механизмаар дамжуулан эрчим хүчний үр ашигтай байдлыг дэмжихэд чиглэсэн агуулгатай. Гэвч хууль эрх зүйн зохицуулалтын тогтолцоо нь нэгдмэл бус, өөр хоорондоо давхцсан 800 гаруй журам байгаа нь институцийн үр ашиггүй байдлыг бий болгож байна.

## ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ОРЧИМ

УИХ-ын 2015 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс эрчим хүчний салбарт баримтлах бодлого (2015–2030) нь Монгол Улсын эрчим хүчний салбарын хууль эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгох, эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тогтвортой байлгах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих замаар эрчим хүчний салбарт шинэчлэл хийх зорилготой байсан юм. Гэвч бодлогын давхардал, хийдлийг арилгах, эрчим хүчний бодлогыг улс орны хөгжлийн өргөн хэмжээний зорилготой уялдуулах зорилгоор энэхүү баримт бичгийг 2021 онд батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хүчингүй болгосон.

Өнөөдөр эрчим хүчний салбарын урт хугацааны бодлогыг тодорхойлж буй баримт бичгүүдийг дурдвал, Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бөгөөд эдгээр нь эрчим хүчний аюулгүй байдал, эх үүсвэрийн төрөлжилтийг дэмжихэд чиглэсэн. Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд, Монгол Улс дараах алсын харааг үе шаттайгаар тодорхойлсон:

- **2025–2030 он:** Дотоодын хэрэгцээгээ бүрэн хангана
- **2030–2040 он:** Эрчим хүч экспортлогч орон болно
- **2040–2050 он:** Цэвэр эрчим хүч үйлдвэрлэгч болно

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг 30%-д хүргэх зорилт дэвшүүлж, Парисын хэлэлцээрээр Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай нийцүүлэн эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг 8.34 сая тонноор бууруулах зорилт тавьсан. 2023 оны байдлаар Монгол Улсад 3 салхин цахилгаан станц, 9 нарны цахилгаан станц, хэд хэдэн жижиг усан цахилгаан станц ажиллаж байгаа бөгөөд эдгээр нь нийлээд суурилагдсан хүчин чадлын 18.3 хувийг бүрдүүлдэг боловч цахилгаан эрчим хүчний бодит үйлдвэрлэлийн ердөө 9.6 хувийг эзэлж байна (НҮБХХ, 2024). Үүнээс үзэхэд, ирэх зургаан жилийн хугацаанд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг 30%-д хүрэх зорилт хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл энэ чиглэлийн

хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Урт хугацааны зорилгын зэрэгцээ Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эрчим хүчийг бүсчилсэн байдлаар хөгжүүлэх зорилт дэвшүүлсэн. Тухайлбал, Баруун бүсийг 2027 он гэхэд эрчим хүчээр бие даан бүрэн хангах зорилго тавьж, "эрчим хүчний төрөлжсөн, эко аялал жуулчлалын дэд бүс" гэж тодорхойлсон. Үүний зэрэгцээ Говийн бүсэд сэргээгдэх эрчим хүч, устөрөгч, байгалийн хийн томоохон хэмжээний үйлдвэрлэлд суурилсан, цаашид экспортлоход чиглэсэн эрчим хүчний нөөцийг бий болгох хүрээнд тус бүсийг "аж үйлдвэрийн болон ногоон эрчим хүчний төв" болгохоор төлөвлөж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5325 МВт цахилгаан эрчим хүч, 1778 МВт дулааны эрчим хүч, 5000 МВт экспортод чиглэсэн эрчим хүч үйлдвэрлэхийг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, эрчим хүчний 35 орчим төслийг хэрэгжүүлэхээр тусгасан. Эдгээрээс 300 МВт-ын Бөөрөлжүүтийн цахилгаан станц (эхний ээлж 150 МВт), Баянгийн 660 МВт-ын дулааны цахилгаан станц (эхний үе шат 330 МВт), Хөвсгөлийн Мөрөнгийн 10 МВт-ын нарны цахилгаан станц болон бусад төсөл хэрэгжиж эхлээд байна.

# ЭРЧИМ ХҮЧНИЙ РЕФОРМ: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТАРИФ, ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ

Дунд болон урт хугацааны үндэсний стратегийн зэрэгцээ одоогийн эвслийн Засгийн газар хууль эрх зүй, үнэ тариф, бүтцийн шинэчлэл зэргийг багтаасан эрчим хүчний реформ хийхээ зарласан билээ.



## ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН РЕФОРМ

2001 онд батлагдсан Эрчим хүчний тухай хуульд 15 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч өмнө нь хийгдсэн шинэчилсэн найруулгууд нь нэг удаагийн шинжтэй, тогтолцоог өөрчлөх хэмжээний томоохон өөрчлөлт болж чадаагүй юм. УИХ-ын 80 дугаар тогтоолоор, хууль, эрх зүйн иж бүрэн шинэчлэл хийх төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Засгийн газар 2025 оны 6 дугаар сард олон жил хүлээгдсэн Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Энэхүү хуулийн төсөл нь төсөл сонгон шалгаруулах шалгуур, үнэ тогтоох механизм, эрчим хүч нийлүүлэх зохицуулалт, өмчлөх эрхийг шилжүүлэх журмыг тодорхой болгох замаар хууль эрх зүйн орчныг шинэчлэх зорилготой. Эдгээр өөрчлөлт нь зах зээлд суурилсан механизмыг нэвтрүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, хувийн хэвшлийн томоохон хөрөнгө оруулалтыг татах зорилготой юм. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг мөн УИХ-д өргөн мэдүүлж, Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлж байна.

УИХ-ын гишүүн С.Цэнгүүн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийн гол хэсгүүдийг олон нийтэд танилцуулсан. Эрчим хүчний яам олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлээгүй,

оролцогч гол талуудын саналыг тусгалгүйгээр хуулийн төслийг өргөн мэдүүлсэн гэдгийг тэрээр онцолж байв. УИХ-ын гишүүн С.Цэнгүүний мэдэгдэлд дурдсанаар, хуулийн төсөлд гурван зүйл бүхий 30 заалт шинээр тусгагдсан бөгөөд төвлөрсөн сүлжээнд холбогдсон сэргээгдэхгүй эрчим хүчний бүтээн байгуулалтыг "эрчим хүчний төсөл" гэж тодорхойлсон хуулийн шинэ үзэл баримтлалыг тусгажээ. Хуулийн төсөлд сэргээгдэх эрчим хүчийг хасаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн тухай хуулийн хүрээнд хэрэгжихгүй төслийн тусгайлсан түншлэлийн хэлэлцээрийн заалтыг тусгасныг дурдав. Энэ нь ТХХТ-ийн хүрээнд бий болсон өргөн хүрээний хууль эрх зүйн орчинтой зөрчилдөж, хийдэл үүсгэж болзошгүйг тэрээр анхааруулсан юм.

Хуулийн төсөлд тусгагдсан өөр чухал заалт нь тусгай зөвшөөрөл өгөх эрхийг Эрчим хүчний зохицуулах хорооноос Эрчим хүчний яаманд шилжүүлсэн явдал юм. Эрчим хүчний сайд даргалж, яамны хоёр төлөөлөл, эрчим хүчний салбарын гурван төлөөллөөс бүрдэх таван хүний бүрэлдэхүүнтэй шинээр байгуулагдах ажлын хэсэг нь төсөл хэрэгжүүлэгчдийг сонгох, хэрэгжүүлэх үндсэн нөхцөл, тухайлбал үнэ тариф, хугацаа, санхүүжилтийн зохицуулалт, шилжүүлэх нөхцөлийг тодорхойлох үүрэг хүлээнэ.

## ҮНЭ ТАРИФЫН РЕФОРМ

Цахилгаан эрчим хүчний салбар санхүүгийн ихээхэн алдагдалтай ажиллаж байна. 2024 онд цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд нэг кВт.ц зардал дунджаар 285 төгрөг байсан бол эцсийн хэрэглэгчид хүрдэг, дундаж тариф ердөө 216 төгрөг байсныг ЭХЗХ дурдсан. 2024 оны байдлаар энэ зөрүүнээс үүдэн богино хугацаат 540 тэрбум төгрөгийн өр, нийт хуримтлагдсан өрийн хэмжээ 1.8 их наяд орчим төгрөг болсон.

Энэхүү алдагдлыг шийдвэрлэх, өвлийн улиралд эрчим хүчний хомсдолд орох эрсдэлийг бууруулах зорилгоор ЭХЗХ-ноос 2024 оны 11 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн, айл өрхийн хэрэглээнд суурилсан гурван шатлалтай тарифын тогтолцоо бий болгож, цахилгаан эрчим хүчний үнийг дунджаар 30 хувиар нэмэгдүүлсэн. Өрхийн дундаж тариф нэг кВт.ц тутамд 280 төгрөг болж, үйлдвэрлэлийн бодит зардалд дөхөж очсон.

(Зураг 2).

Дулаан халаалтын тухайд Эрчим хүчний зохицуулах хорооноос халаалт, цахилгаан эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт хийх шийдвэр гаргасан боловч айл өрхөд нийлүүлэхэд дулааны үнийг нэмэх асуудлыг 2026 оны нэгдүгээр сар хүртэл хойшлуулаад байна.

Өнөөгийн байдлаар, Улаанбаатар хотын айл өрхүүд 1 сард ам метр талбайдаа 506 төгрөг төлж байгаа нь дулаан үйлдвэрлэхэд гардаг бодит зардлын дөнгөж 40 хувь болж байна. Жишээлбэл, ердийн 50 м<sup>2</sup> талбайтай орон сууцанд амьдардаг иргэн сард 27,000 төгрөгийн (НӨАТ орсон) дулааны төлбөр төлдөг бөгөөд дулаан үйлдвэрлэхэд зарцуулсан зардлыг нөхөхийн тулд м<sup>2</sup> тутамд 2,505 төгрөг төлөх шаардлагатай байгаа нь одоо байгаа тарифаас тав дахин их байна. Сэлбэ дулааны станц зэрэг шинээр байгуулагдах станцууд ийм өндөр өртгөөр ажиллах төлөвтэй байна. Харин үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд нэг мкв талбайн үнэ 604–1208 төгрөг төлж байгаа нь цаашид хоёр дахин нэмэгдэхээр байна.

2025 оны 9-р сарын 16-наас эхлэн халуун, хүйтэн усны тарифт өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаа боловч ямар хувь хэмжээгээр өөрчлөгдөх нь тодорхойгүй байна. Эдгээр реформ нь төсвийн бодлогын хувьд зайлшгүй шаардлагатай боловч нийтэд нь үзүүлэх нөлөө нь богино хугацаанд айл өрхийн төсөвт ихээхэн хүнд тусахаар байна.



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО** **УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК**

## АЙЛ ӨРХӨД ШИНЭЭР МӨРДӨЖ БУЙ ЦАХИЛГААНЫ ҮНЭ

| хэрэглээний шатлал | өдөр | шөнө |
|--------------------|------|------|
| 0-150 кВт.ц        | 182₮ | 147₮ |
| 150-300 кВт.ц      | 225₮ | 160₮ |
| 300+ кВт.ц         | 265₮ | 160₮ |

**300+ кВт.ц-аас их хэрэглээнд** төлбөрийн нэмэгдэл 60%-аас дээш

**150 кВт.ц-аас бага хэрэглээнд** төлбөрийн нэмэгдэл 30%-аас доош

**ЭРЧИМ ХҮЧЭЭ ХЭМНЭЭ!**

"Зураг 2. Цахилгаан эрчим хүчний тарифын өөрчлөлт"

Институцийн хувьд авч үзвэл, эрчим хүчний салбарт зохицуулалт хийх, үүрэг нь давхардсан хэд хэдэн байгууллага байна. Эрчим хүчний яам нь үндэсний стратегийг хэрэгжүүлдэг бол ЭХЗХ үнэ тариф тогтоох, тусгай зөвшөөрөх олгох, дагаж мөрдөх журмыг батлан ажилладаг. Диспетчерийн үндэсний төв нь цахилгааны эрчим хүчний системийн үйл ажиллагааг удирдан, явуулдаг.

Засгийн газар эрчим хүчний салбарын уялдаа холбоог сайжруулах үүднээс салбарын хэмжээнд 2024 онд хэрэгжүүлэх реформын хөтөлбөрт хяналт тавих зорилгоор Эрчим хүчний реформын үндэсний хороог мөн байгуулсан. Гэвч 2025 оны 6 дугаар сард хамтарсан Засгийн газар огцорсны дараа тус хороог татан буулгажээ. Мөн 2025 онд Засгийн газрын тогтоолоор Диспетчерийн үндэсний төв, Улаанбаатар дулааны цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ, Дулааны II, III, IV цахилгаан станц, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компани зэрэг Монголын томоохон эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, сүлжээ оператор болох уул уурхайн бус төрийн өмчит 44 аж ахуйн нэгжид тавих удирдлага, хяналтыг нэгтгэх зорилгоор төрийн өмчит "Эрчимт Монгол" ТӨХК-ийг байгуулсан.

Засгийн газраас хэрэгжүүлж буй реформын ажлын хүрээнд эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийх тухай ТОГТООЛ 2025 оны 7 дугаар сард батлагдсан. Энэ реформ нь эрчим хүчний тасралтгүй, аюулгүй, найдвартай ажиллагааг хангах, үйл ажиллагааны зардлыг бууруулах, үйл ажиллагааны давхцал, цоорхойг арилгах, нийт үр ашгийг дээшлүүлэх зорилготой юм.

Энэ тогтоолын дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д нэгтгэсэн.

Цахилгаан эрчим хүч түгээх бүсийн хэд, хэдэн байгууллагыг хооронд нь нэгтгэж, үүнд:

- Увс цахилгаан түгээх сүлжээ ХХК, Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХК, Дөргөний усан цахилгаан станц ХХК, Мянгадын нарны цахилгаан станцыг нэгтгэж, Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийг шинээр байгуулсан.
- Хуучин Алтай-Улиастайн эрчим хүчний системийн түгээх салбаруудыг нэгтгэн Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийг байгуулсан байна.
- Тайшир-Гуулин усан цахилгаан станц ХХК, Богд голын усан цахилгаан станц ХХК, Тосонцэнгэлийн усан цахилгаан станц ХХК, Сэрвэн, Мөрөн, Борхоны нарны цахилгаан станцууд, Хүнгүй-Галуутайн усан цахилгаан станцыг нэгтгэн, "Тайшир ногоон эрчим" ТӨХК-ийг шинээр байгууллаа.

Үүний үр дүнд, өмнө нь бие даан үйл ажиллагаа явуулдаг байсан төрийн өмчит есөн компани, тэдгээрийн найман салбар нэгжийг 4 аж ахуйн нэгжид нэгтгэн, нэгдсэн зохион байгуулалтад оруулсан юм.

Реформ нь чиг үүргийн давхардлыг багасгах, зохицуулалтыг сайжруулах, арилжааны болон бодлогын чиг үүргийг салгах зорилготой боловч институцийн, ялангуяа тариф тогтооход нүүрлэсэн салангид байдал, зохицуулалтын үйл ажиллагааны тогтворгүй байдал, ТӨХК-уудын хариуцлагын асуудал саад тотгор болж байна. Чиг үүргүүд нь давхацсан, хэрэгжилт удаашралтай байгаа нь тариф тогтоох, сэргээгдэх эрчим хүчний гэрээ байгуулах, ТӨХК-уудын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөөр байна.

# ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ: СЭРГЭЭГДЭХ БОЛОН ЦЭВЭР ЭРЧИМ ХҮЧ

Монгол Улсад эрчим хүчний шилжилт чухал үе шатандаа байна. Нүүрс эрчим хүчний холимогт давамгайлсан хэвээр байгаа боловч Засгийн газраас 2030 он гэхэд суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30%-д хүргэх, [Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалттайгаа](#) уялдуулан салбарын хэмжээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зэрэг уур амьсгал, эрчим хүчний томоохон зорилтуудыг Алсын хараа-2050 болон Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн. Гэвч сэргээгдэх эрчим хүч цахилгаан эрчим хүчний өнөөгийн үйлдвэрлэлийн 18.3%-иас бага хувийг эзэлж байгаа нь дэд бүтэц, зохицуулалт, хөрөнгө оруулалтын ихээхэн саад тотгор нүүрлэснийг харуулж байна.

Энэ хүрээнд устөрөгч, сэргээгдэх эрчим хүч, хуримтлуур, сүлжээний шинэчлэл зэргийг хамруулсан цэвэр эрчим хүч нь эрчим хүчний үндэсний хэмжээний тэргүүлэх зорилтуудын эхний эгнээнд эрэмбэлэгдэх боллоо.



## УСТӨРӨГЧИЙН СТРАТЕГИ

Эрчим хүчний шилжилтийн өргөн хүрээг хамарсан зорилтын хүрээнд, химийн аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих чиг үүрэг бүхий Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зарлигаар байгуулагдсан Ажлын хэсгийн санаачилгаар Монгол Улс Устөрөгчийн үндэсний стратеги анх удаа боловсруулж, батлах шатандаа явж байна. Устөрөгчийг хөгжүүлэх бодлогыг баримталж буй нь дотоод, гадаад үндэслэлтэй. Дотоодын бодлогын тухайд, энэхүү стратеги нь ногоон хөгжлийг тогтвортой өсөлтийн үндэс гэж тодорхойлсон Алсын хараа-2050-тай нягт уялдана. Монгол Улсын нийт хүлэмжийн хийн ялгаруулалт дэлхийд дөнгөж 0.06%-ийг эзэлдэг боловч нэг хүнд ногдох ялгаруулалтын хэмжээгээр дэлхийн болон бүс нутгийн дунджаас нэлээд дээгүүр хэвээр байгаа нь илүү цэвэр, хүлэмжийн хийн ялгаруулалт багатай эрчим хүчийг нэвтрүүлэх замаар эх үүсвэрээ төрөлжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Гадаад бодлогын тухайд, энэхүү стратеги нь олон улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд Монгол Улсын хүлээсэн үүрэг зорилтууд, тэр дундаа Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг

амлалтаа биелүүлэх, дэлхийн хэмжээнд хүлэмжийн хийн ялгаралгүй болоход чиглэсэн өргөн цар хүрээг хамарсан хүчин чармайлтад хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзлийг харуулдаг. Устөрөгчийг Монголын сэргээгдэх нөөц болон цэвэр эрчим хүчний бүс нутгийн эрэлт хэрэгцээг хооронд нь холбох боломжит гүүр гэж үздэг.

Ерөнхийлөгчийн Тамгын газар, салбарын яамд, зохицуулах агентлагууд, хөгжлийн түншүүд, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагууд, бизнесийн холбоод, иргэний нийгэм зэрэг өргөн хүрээний оролцогч талуудтай зөвлөлдөх замаар Устөрөгчийн стратегийн төслийг боловсруулсан. 2024 оны 10 болон 12 дугаар сард оролцогч талуудын хэлэлцүүлгийг хийсэн бол 2025 оны 2 дугаар сараас 5 дугаар сарын хооронд фокус бүлгийн хэлэлцүүлэг, тоймыг хэд хэдэн удаа зохион байгууллаа. Дараагийн алхам болгон Монгол Улсын устөрөгчийн үндэсний стратегийн төслийг эцэслэн боловсруулж, батлахаас өмнө Засгийн газрын буюу гүйцэтгэх засаглалын болон бодлогын түвшинд хэлэлцүүлэх шаардлагатай юм.

## ЦЭВЭР ДЭД БҮТЦИЙН САНХҮҮЖИЛТ

Эрчим хүчний шилжилт өрнөж буй энэ үед, хөгжлийн олон талт түншүүд сүүлийн хорин жилийн хугацаанд Монгол Улсын эрчим хүчний салбарт хөнгөлөлттэй санхүүжилт олгох, техникийн туслалцаа үзүүлэх, зорилтот төслийн дэмжлэг үзүүлэх зэргээр чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Тухайлбал, Улаанбаатар хот анхны орон нутгийн ногоон бондоо 2025 онд гаргахад ОУСК дэмжлэг үзүүлсэн. Бондоор босгосон санхүүжилтийг Багануур дүүрэгт 50 МВт-ын хүчин чадалтай эрчим хүч хуримтлуурын станц барих ажилд зарцуулсан.

Эрчим хүч хуримтлуулахаас гадна ОУСК нь Мандалговьд 100 МВт-ын салхин станцын төслийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэх үйл явцыг дэмжиж, ТХХТ-ийг бий болгоход дэмжлэг үзүүлж байна. ОУСК-ийн тооцоолсноор, Монгол Улс уур амьсгал, хөгжлийн зорилтоо биелүүлэхийн тулд ирэх 25 жилийн хугацаанд эрчим хүчний салбарт 10 гаруй тэрбум ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байгаа юм.

## СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Засгийн газар болон ЕСБХБ нь тус улсын ногоон эрчим хүчний шилжилтийг дэмжих зорилгоор 2028 он гэхэд 1 тэрбум ам.долларын санхүүжилт хийх тухай [харилцан ойлголцлын санамж бичигт](#) 2025 оны 1 дүгээр сард гарын үсэг зурсан. Энэхүү гэрээнд 300 МВт-ын нар, 200 МВт-ын салхины хүчин чадлыг барьж байгуулах, нэгтгэсэн

хуримтлуур болон дамжуулах дэд бүтцийг бий болгох боломжтой хамтарсан санхүүжилт багтсан болно. ЕСБХБ нь Монгол Улсын анхны салхин парк болох Салхит салхин станцыг байгуулах болон дараа, дараагийн төслүүдийг хамтран санхүүжүүлэх зэргээр Монголын сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг эхнээс нь дэмжсээр ирсэн.

## СҮЛЖЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛ БОЛОН БУСАД АЖИЛ

АХБ нь сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, эрчим хүчний сүлжээг шинэчлэх, эрчим хүчний нийт салбарыг нүүрстөрөгчөөс ангижруулахад чиглэсэн, зорилтот хөрөнгө оруулалтаар дамжуулан Монгол Улсын цэвэр эрчим хүчний шилжилтийг дэмжиж, 1993 оноос хойш 40 гаруй эрчим хүчний төсөлд 450 сая гаруй ам.долларын санхүүжилт олгосон. Үүний дотроос Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл (UREP) болон Эрчим хүч хуримтлуулах

системийн төсөл (BESS) зэрэг 2 гол төсөлд анхаарч ажиллаж байна. 2025 оны 5 дугаар сарын байдлаар UREP төсөл нь нийт 65,327 МВт/цаг цэвэр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг ойролцоогоор 58,337 тонноор бууруулсан байна. Үүний зэрэгцээ, BESS төсөл нь ойролцоогоор 80,000 тонн CO2 ялгаруулалтаас зайлсхийж, ~94,500 МВт цаг цэвэр эрчим хүч нийлүүлсэн байна.

# ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ



Монголын эрчим хүчний систем төсвийн хөрөнгө оруулалт, хөгжлийн санхүүжилтэд түшиглэж ирсэн боловч цэвэр эрчим хүчний чадавхыг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, томоохон хэмжээний дэд бүтцэд хөрөнгө оруулахад хувийн хэвшлийнхэн хурдасгагч үүргийг илүүтэй гүйцэтгэж эхлээд байна.

Хувийн хөрөнгө оруулагчид ээдрээтэй нөхцөл байдалд зохицон ажиллах шаардлагатай болж байгаа билээ. Тухайлбал үнэ тарифын тогтолцоо нь шинэчлэгдсэн хэвээр байгаа, сүлжээний интеграцлал нь техникийн бэрхшээлтэй тулгардаг, урт хугацааны цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээ байгуулах нь хязгаарлагдмал байдаг. Гэсэн хэдий ч хууль эрх зүй, зохицуулалтын орчин шинэчлэгдэхийн хэрээр хувийн хэвшлийн гаргасан санаачилга нь Монгол Улсын эрчим хүчний шилжилтэд чухал хувь нэмэр оруулж болохыг сонгогдсон оролцогч талууд харуулж байна.

## КЕЙС СУДАЛГАА: Ю ПИ СИ РЕНЬЮБЕЛС (UPC RENEWABLES)

Ю Пи Си Реньюбелс нь дэлхийн 16 оронд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, олон улсын хэмжээнд цэвэр эрчим хүч үйлдвэрлэгч компани бөгөөд Монгол Улсад салхи, эрчим хүчний хуримтлуурын чиглэлээр олон төсөл санаачилсан. Эдгээр төслийг заримыг нь дурдвал:

### Чойрын салхин цахилгаан станц + BESS

50 МВт-ын салхин цахилгаан станц нь Чойр хотын ойролцоо баригдах 20 МВт-ын эрчим хүчний хуримтлуурын системтэй хосолсон бөгөөд сүлжээний найдвартай байдлыг хангах, оргил ачааллын менежментийг сайжруулах зорилготой.

### Говь I Мега салхин цахилгаан станцын төсөл

Говийн бүсэд хэрэгжүүлэхээр санал болгож буй 2000 МВт-ын салхины төсөл нь эрчим хүчийг дотоодын болон экспортын боломжит зах зээлд нийлүүлэх зорилготой.

### Дундговь Мега салхин цахилгаан станцын төсөл

2025 оны 4 дүгээр сард Ю Пи Си Реньюбелс нь Эрчим хүчний реформын үндэсний хороотой Дундговь аймагт 2400 МВт-ын хүчин чадалтай салхин цахилгаан станцыг хөгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. 2 тэрбум ам.долларын үнэлгээтэй энэхүү төсөл нь Монгол Улсын түүхэн дэх хамгийн том хувийн цэвэр эрчим хүчний хөрөнгө оруулалтын нэг юм.

## ХУВИЙН ХЭШЛИЙН САЛБАРЫГ ИЛҮҮ ӨРГӨН ХҮРЭЭНД ОРОЛЦУУЛАХЫН ҮР НӨЛӨӨ

Ю Пи Си Реньюбелс нь амжилттай хэрэгжсэн эрчим хүчний загвар санал болгодог боловч тухайн загварыг хэрэгжүүлэх нь системийн сайжруулалтаас хамаардаг. Зохицуулалт тодорхой байх, зөвшөөрөл олгох үйл явц жигдэрсэн, ил тод өрсөлдөөнт тендер байх нь илүү олон хувийн хөрөнгө оруулагчдыг татахад чухал юм. Сүлжээний шинэчлэл хийх, эрчим хүчийг урт хугацаанд төлөвлөх нь хувийн хэвшлийн сонирхол, үйл ажиллагааг тогтвортой байлгах урьдач нөхцөл болно.

Монгол Улс хандивлагчдын тусламж дэмжлэгт суурилсан байдлаар эрчим хүчний салбараа хөгжүүлдэг байснаа өөрчилж, зах зээлд суурилсан эрчим хүчний хөгжлийг бий болгохоор зорьж байгаа энэ үед хувийн салбарыг дэмжих хөшүүргийг төрийн зорилготой уялдуулах тогтолцоог бий болгох нь амин чухал юм. Ю Пи Си Реньюбелсын жишээ нь хувийн хэвшлийн оролцоо нь зөв нөхцөлд инновацыг өргөжүүлж, нүүрстөрөгчийн ялгаруулалтаас ангижрах үйл явцыг хурдасгаж, эдийн засгийн өсөлтийн шинэ гарцуудыг нээж чадна гэдгийг харуулж байна.

# КАЗАХСТАН УЛСЫН СУРГАМЖ: НҮҮРСЭД ХЭТ СУУРИЛСАН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМЭЭ ШИНЭЧИЛСЭН НЬ



Казахстан нь Монгол Улсын нэгэн адил, Төв Азид орших, далайд гарцгүй улс бөгөөд цахилгаан эрчим хүчний хангамжийнхаа 66.7%-ийг нүүрсээр хангадаг, Зөвлөлтийн үеийн хуучирсан дэд бүтэцтэй, эрчим хүчний дутагдлаа ОХУ-аас импортолдог цахилгаан эрчим хүчээр хангадаг зэрэг эрчим хүчний сорилтууд тус улсад мөн адил тулгардаг ([НҮБХХБХ, 2025](#)). 2016 оноос эхлэн тус улс эрчим хүчний салбартаа шинэчлэл хийж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, цахилгаан эрчим хүчний сүлжээгээ шинэчлэх зорилготой хэд, хэдэн хууль тогтоомжийг баталсан.

2023 онд Ерөнхийлөгч К.Токаев Казахстан улсыг 2060 он гэхэд нүүрстөрөгчийн саармаг байдалд хүрэх стратегийг баталсан нь үндэсний хэмжээнд ногоон эрчим хүч рүү шилжих шилжилтийг тодорхойлж харуулж өгсөн ([ODI Global, 2024](#)). Тус улс эрчим хүчний нийт хэрэглээгээ хангах хэмжээний нар, салхи, усны арвин нөөцтэй. Тус улс жилд 920 тэрбум кВт.ц сэргээгдэх эрчим хүч ашиглах шаардлагатай гэсэн тооцоо байдаг бол хүн ам нь жилд ердөө 828 тэрбум кВт.цаг цахилгаан хэрэглэдэг. 2018 онд засгийн газар чулуужсан түлшнээс сэргээгдэх эрчим хүч рүү шилжих үйл явцыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хувийн компаниудаас нийлүүлэх салхи, нарны эрчим хүчийг худалдан авахад өрсөлдөөнт сонгон шалгаруулах системийг хэрэгжүүлсэн. Энэ нь тус улсад нийт 0,05 кВт-ын хүчин чадалтай 5 ГВт цахилгаан эрчим хүчийг ашиглах боломжийг олгож, Казахстаны сэргээгдэх эрчим хүчний үнийг мэдэгдэхүйц бууруулахын зэрэгцээ эрчим хүчний салбарт гадаад, дотоодын компаниудын оролцоог нэмэгдүүлэхэд тус дөхөм болсон.

Казахстаны өнөөгийн эрчим хүчний сүлжээний байдлыг авч үзвэл, Зөвлөлтийн үед баригдсан бөгөөд эрчим хүчний үйлдвэрлэлийн нийлүүлж чадахгүй байгаа дутууг нөхөх зорилгоор ОХУ-аас эрчим хүчээ хангасан хэвээр байна. Ногоон ирээдүйг дэмжих зорилгоор тус улс ус, нар, салхины эрчим хүчийг нэгтгэх боломжийг бий болгохын тулд цахилгаан эрчим хүчний сүлжээгээ шинэчлэх шаардлагатай болох юм. Цаашилбал, одоо байгаа дэд бүтэц нь баруун бүс нутаг зэрэг Казахстаны хөдөө тосгоны хөгжилд дэмжлэг болохгүй байна. Тус улсын төв болон зүүн хэсэгт орших томоохон хот сууринаас гадуур амьдарч буй иргэдийн эрчим хүчний аюулгүй байдлыг хангахын тулд Казахстан улс одоо байгаа эрчим хүчний сүлжээгээ шинэчлэх шаардлагатай болно. Түүнчлэн, системийг шинэчилснээр тус улсын нийт эрчим хүчний 15 хувьтай тэнцэх, дамжуулах болон түгээх явцад алдагдсан цахилгаан эрчим хүчний хэмжээг бууруулж болно. Эрчим хүчний сүлжээг шинэчлэх нь сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг хөнгөвчлөх, дотооддоо үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг нэмэгдүүлэх ач холбогдолтой ([АНУХЯ, 2022](#)).

Монгол Улс болон Казахстаны аль аль нь эрчим хүч, цахилгааны эх үүсвэрээ нүүрснээс гаргаж авдаг байсан, сэргээгдэх эрчим хүч рүү шилжиж буй байгалийн баялаг ихтэй улсууд юм. Ирээдүйд ногоон эрчим хүч рүү шилжих зорилтуудтайгаа уялдуулан хоёр улс дотооддоо нар, ус, салхины эрчим хүч үйлдвэрлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө

оруулалтыг дэмжих зорилгоор ижил төстэй хууль тогтоомжийг нэвтрүүлсэн. Мөн хоёр улсын засгийн газар цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх явцад гардаг хаягдлыг бууруулах, тус тусын улсын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй иргэдийг эрчим хүчээр хангах зорилгоор сүлжээгээ шинэчлэх, өргөжүүлэх арга хэмжээ авч байна. Хоёр улс ирээдүйн стратеги, өнөөгийн нөхцөл байдал нь геополитик, эдийн засгийн өөрчлөгдөж буй орчинд дасан зохицох явцад ижил төстэй сорилтуудыг дагуулдаг төдийгүй олон ижил төстэй талуудтай.

Казахстан болон Монгол Улс эрчим хүчний түгээлт, үйлдвэрлэл, эрчим хүчний дэд бүтцийн шинэчлэлд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх явдлыг эн тэргүүнд тавих шаардлагатай. Хоёр улс дуудлага худалдааг олон улсад өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийг ногоон эрчим хүчний төслүүдэд хөрөнгө оруулах эсвэл хуучирсан дэд бүтцийг шинэчлэхэд ажиллуулах хэрэгсэл болгон ашиглаж ирсэн. Хоёр улсын эрчим хүчний хараат бус байдлыг хангах, үр ашгийг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүч рүү шилжих зэрэг зорилт амжилтад хүрэх эсэх нь зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, цахилгаан эрчим хүчний хүртээмжийг өргөжүүлэхээс хамаарна.

# ЗӨВЛӨМЖ

Урт хугацааны хөгжлийн алсын хараатай уялдуулан эрчим хүчний аюулгүй байдал, тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтийг хангахын тулд засгийн газар хувийн хэвшлийн оролцоог эрчимжүүлж, дэд бүтцийг шинэчлэх, хүртээмжтэй, *шударга шилжилтийг* хангахуйц зоригтой шинэчлэл, стратегийн хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд тавих ёстой.

1

## **Хувийн хөрөнгө оруулалтыг бий болгох, салбарын шинэчлэлийг хийхийн тулд хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, тодорхой болгох**

Эрчим хүчний орчин комплекс байдлаар өөрчлөгдөж байгаа хэдий ч 2001 онд батлагдсан Эрчим хүчний тухай хуульд бүтцийн хэмжээний томоохон өөрчлөлт ороогүй байна. Хуулийн тодорхой заалтууд нь төсөлд хамрагдах байдал, өрсөлдөхүйц сонгон шалгаруулах шалгуур, үнэ тариф тогтоох механизм, хэрэгжилтэд тавих хяналт зэргийг тодорхой болгож өгөх нь чухал юм. Хоёр талын хэлцэл болон түр шийдвэрээр аргаадаг явдлыг багасгахын тулд дүрэм журамд суурилсан тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай. Бодлогын ололт амжилтаас ухрахаас сэргийлэхийн тулд, эрчим хүчний төслийн хуулийн тодорхойлолтод сэргээгдэх эрчим хүчийг мөн тодорхой тусгах шаардлагатай. Цаашид хийгдэх зохицуулалтын өөрчлөлт нь төслийн зардалд хэрхэн нөлөөлж болох, тэр дундаа төлөвлөгдөөгүй хууль эрх зүйн дарамтаас болж хөрөнгө оруулагчдын хүлээх хариуцлагыг хязгаарлах эсэх зэргийг тодруулах замаар хууль хамгаалалтыг тодорхой болгох нь чухал.

2

## **Байгууллагуудын зохицуулалтын үүргийн давхардлыг арилгах, тодорхой болгох замаар засаглалыг бэхжүүлэх**

Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо болон олон эрх бүхий байгууллагаас бүрдэх эрчим хүчний өнөөгийн засаглалын бүтэц нь үр ашиггүй байдлыг бий болгож, хөрөнгө оруулагчдад тодорхойгүй байдлыг төрүүлж байна. Реформ нь байгууллагуудын эрх, үүргийг оновчтой болгож, хариуцлагыг дээшлүүлж, үйл ажиллагааны бие даасан байдлыг хадгалахад чиглэгдэхийн зэрэгцээ давхардсан чиг үүргээс зайлсхийхэд чиглэсэн байх шаардлагатай. Нэгдмэл, ил тод, уялдаатай зохицуулалтын орчин нь урт хугацаанд салбарын итгэл хүлээх байдлыг хангахад зайлшгүй чухал.

3

## **Эрчим хүчний урт хугацааны нэгдсэн төлөвлөлтийг хувийн хэвшлийн идэвхтэй оролцоотойгоор институцлэх**

Эрчим хүчний бодлого нь хариу үйлдэл үзүүлж, зөвшөөрөл олгодог байдлаас ангижирч, урьтсан, өгөгдөлд суурилсан төлөвлөлт рүү шилжих шаардлагатай байна. Алсын хараа-2050, дунд хугацааны стратегийн бодлого, хөгжлийн зорилттой уялдуулан үе үе хийж байх эрэлтийн таамаглал, хөрөнгө оруулалтын замын зураглал, сүлжээ төлөвлөлт зэрэг нь үүнд мөн хамаарна. Зөвхөн төсөл боловсруулагч төдийгүй бодлого боловсруулах, хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх, хэрэгжүүлэх стратегийн түншийн хувиар, хувийн хэвшлийнхэн эрчим хүчний үндэсний стратегийг боловсруулахад эхнээс оролцох шаардлагатай.

4

## **Эрсдэлийг бууруулах арга хэрэгсэл, холимог санхүүжилтээр дамжуулан хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэх**

Хандивлагчдаас хамааралтай байдлаас зах зээлийн тогтолцоонд шилжихийн тулд Монгол Улс хувийн хөрөнгө оруулалтыг өргөн хүрээнд татах шаардлагатай байна. Үүнд төрөөс батлан даасан зээлийн баталгаа, ногоон бонд гаргах, нүүрстөрөгчийн кредитийг мөнгөн эргэлтэд оруулах, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, эрсдэлийн баталгаа гаргах зэргийг нэгтгэсэн холимог санхүүгийн хэрэгслүүд шаардлагатай боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй юм. Засгийн газар хөгжлийн түншүүдтэй хамтран эрчим хүчний үйлдвэрлэл, хуримтлуур, цахилгаан эрчим хүчний дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөлийг бүрдүүлэх боломжтой.

5

#### **Орон нутгийн санхүүгийн тогтолцоогоор дамжуулан төвлөрсөн бус сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдийг өргөжүүлэх**

Нарны PV цахилгаан үүсгүүр болон хуримтлуурын амжилттай, ялангуяа сүлжээнд холбогдоогүй болон гэр хорооллын бүсэд хэрэгжүүлсэн, туршилтын төслүүдийг өргөжүүлэх нь өрхийн эрчим хүчний зардлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах, эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэхэд тустай. Дотоодын санхүүгийн байгууллагууд болон ЖДҮ-тэй хамтран ажиллах нь орон нутагт тохирсон зээл олгох, нийлүүлэх загвараар дамжуулан хямд өртгөөр нийлүүлэх цэвэр эрчим хүчийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

6

#### **Алдагдлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчийг сүлжээнд нэгтгэхэд сүлжээний шинэчлэлийг нэн тэргүүнд эрэмбэлэн, чухалчлах**

Цахилгаан эрчим хүчний дамжуулалтын алдагдал 13%-иас дээш байгаа нь дэд бүтэц хуучирсан байгааг харуулж, сэргээгдэх эрчим хүчийг сүлжээнд нэгтгэхэд саад болж байна. Үндэсний сүлжээг шинэчлэх хөтөлбөрийн хүрээнд дижиталчлал, нөөцийн систем болон бүс нутаг хоорондын харилцан холболтыг хангах, үндэсний нэгдсэн сүлжээг бүрэн барьж дуусгах зэргийг хийх нь зүйтэй. Эдгээр шинэчлэл нь эрчим хүчний найдвартай байдлыг хангах, нүүрстөрөгчийн ялгаруулалт багатай хөгжлийг бий болгох урьдач нөхцөл болно.

7

#### **Зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг нэг цэгийн механизмаар дамжуулан хялбарчлах**

Удаан хугацаа шаарддаг, төрийн үйлчилгээ нь олон талд тусдаа байдгаас зөвшөөрөл олгох үйл явц нь бэрхшээлтэй хэвээр байна. Дижитал байдлаар юмуу эсвэл нэг цонхны үйлчилгээгээр дамжуулан зөвшөөрлийн нэгдсэн механизм бий болгох нь цаг хугацаа алддаг байдлыг багасгаж, гүйлгээний зардлыг бууруулж, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад харагдах төслийн найдвартай байдлыг сайжруулж чадна.

8

#### **Гүйцэтгэл, нийгмийн хамгаалалтай уялдуулан шилжилтийн тарифын төлөвлөгөөг гаргах**

2024 онд эхлүүлсэн тарифын зохицуулалт нь эрчим хүчний салбарт нэн шаардлагатай байсан боловч улс төрийн хувьд эмзэг сэдэв юм. Монгол Улс зорилтот татаасаар дамжуулан эмзэг бүлгийн өрхүүдийг хамгаалах бодлого хэрэгжүүлэхийн зэрэгцээ жижиглэнгийн үнийг зардлаа нөхөхүйц байлгахаар үе шаттайгаар шинэчлэл хийх замаар олон жилийг хамарсан, ил тод тарифын төлөвлөгөөг батлах шаардлагатай байгаа юм. Үйлчилгээний чанарыг урамшуулах, алдагдлыг бууруулах зорилгоор эрчим хүчний байгууллагууд гүйцэтгэлд суурилсан нөхөн олговор авдаг болох нь чухал. Үүний зэрэгцээ олон нийтийн харилцаа, хэрэглэгчийн итгэлцэл нь реформыг үргэлжлүүлэхэд чухал үүрэгтэй байна.

9

#### **Эрчим хүчний реформыг үргэлжлүүлэх хэрэгжүүлэхэд улс төрийн залгамж байдлыг хадгалах, намуудын зөвшилцлийг бий болгох**

Монгол Улсын эрчим хүчний стратеги улс төрийн мөчлөгөөс ангид байх нь чухал. Хууль, эрх зүйн шинэчлэл, ТӨК-уудын бүтцийн өөрчлөлт, цэвэр эрчим хүчний хөгжлийг ирээдүйн засаг захиргаагаар дамжуулан хэрэгжүүлэхэд намуудын дэмжлэг шаардлагатай. Урт хугацааны хөрөнгө оруулалтыг татах, реформын эрчийг сонгуулийн хугацаанаас ангид байлгахад тогтвортой, урьдчилан таамаглахуйц бодлогын орчин чухал билээ.

# ДҮГНЭЛТ

Монгол Улс эрчим хүчний шилжилтийн эгзэгтэй үе дээрээ ирээд байна. Тус салбар нь нүүрснээс ихээхэн хамааралтай, гадаад нийлүүлэлтийн шоконд өртөмтгий, хоцрогдсон дэд бүтцээс үүдэлтэй сорилт бэрхшээлтэй тулгарсан хэвээр байна. Хүн амын 98 гаруй хувь нь цахилгаан эрчим хүч хэрэглэж байгаа боловч найдвартай байдал, боломжийн үнэ, тогтвортой байдал зэргийг хангах зэрэг нь байнгын сорилт бэрхшээл болсоор байна. Нүүрс эрчим хүчний хангамжийн 70%, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 85 гаруй хувийг бүрдүүлсээр байгаа Монгол Улс нь эрчим хүчний холимгоо төрөлжүүлэх, сүлжээгээ шинэчлэх, сэргээгдэх болон цэвэр эрчим хүчний шийдлүүдийг өргөн хүрээнд нэвтрүүлэхийг зорьж байна.

Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хууль тогтоомж, стратегийн үндсэн баримт бичиг нь 2030 он гэхэд эрчим хүчний бие даасан байдлыг бий болгож, сэргээгдэх эрчим хүчийг суурилагдсан хүчин чадлын 30%-д хүргэх, Парисын хэлэлцээрээр хүлээсэн Монгол Улсын үүрэг амлалттай нийцүүлэх зэрэг томоохон зорилтуудыг тавьсан. Гэвч зохицуулалтын үйл ажиллагаа олон байгууллагуудад хуваагдсан, институцийн зохицуулалт сул, дэд бүтцийн шинэчлэлийн ажил удаашралтай байгаа гэх мэт шалтгаан нь эдгээрийн баримт бичгийн хэрэгжилтэд саад тотгор учруулж байна.

Засгийн газар эрчим хүчний салбарын реформын хөтөлбөрийг нэн тэргүүнд тавьсан. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг эрх зүйн чухал шинэчлэл хийгдэж байна. 2024 онд эхлүүлсэн цахилгаан, дулааны тарифын шинэчлэл нь төсвийн алдагдлыг бууруулж, үйлдвэрлэлийн зардал болон хэрэглээний үнийн зөрүүг арилгахад чиглэгдсэн.

Сэргээгдэх эрчим хүч, цэвэр дэд бүтцийн бодлогын зорилтууд нь хөгжлийн түншүүдийн хүчтэй оролцоогоор урагшилж, дэмжигдэж байна. Устөрөгчийн үндэсний стратеги боловсруулагдаж байгаа бөгөөд АХБ, ОУСК, ЕСБХБ зэрэг олон талт байгууллагууд санхүүжилт, хуримтлуурын систем, сүлжээний шинэчлэл болон бусад дэмжлэг үзүүлж байна. Сэргээгдэх эрчим хүч нь суурилагдсан хүчин чадлын 18.3 хувийг эзэлдэг боловч цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 10 хүрэхгүй хувийг эзэлж байгаа нь хувийн хэвшлийн оролцоог хурдтай нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Ю Пи Си Реньюбелс зэрэг хувийн хөрөнгө оруулагчид салхины цахилгаан станц, эрчим хүчний хуримтлуурын томоохон төслүүдийг боловсруулж эхэлсэн. Гэвч илүү өргөн хүрээний хөрөнгө оруулалтыг нээж, цэвэр эрчим хүчийг нэмэгдүүлэх боломжийг бий болгохын тулд зохицуулалтыг илүү тодорхой болгох, урт хугацаатай эрчим хүч худалдан авах гэрээ байгуулдаг болох, сүлжээг шинэчлэх зайлшгүй шаардлагатай юм.

Цаашид Монгол Улс зохицуулалтыг илүү оновчтой болгох, орчин үеийн сүлжээний дэд бүтэц барьж байгуулах, хөрөнгө оруулагчдад тохирсон эрчим хүчний төлөвлөлт хийх зэргийг нэн тэргүүнд тавих шаардлагатай. Казахстан зэрэг улс орнуудын туршлагаас хандивлагчдын оролцоотой хөгжлөөс өрсөлдөөн, зах зээлд тулгуурласан эрчим хүч рүү хэрхэн шилжиж болохыг харж, сургамж авч болох юм.

